



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/134/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Алтай хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: М.Атарцэцэг
Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn
Аудитор: Н.Гэрэлмаа
Утас: 99782918 Цахим хаяг: gerelmaan@audit.gov.mn



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

Ауд. О.А. 12 № 4

танай _____-ны № _____-т

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА
О.БААТАРЧУЛУУН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйцгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын онцолсон хэсэг

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрүүл мэндийн салбарт 3 барилга шинээр, 1 эрүүл мэндийн төвийн барилгад их засвар хийж ашиглалтад оруулсан байна.

Багийн эмч нарыг унаажуулах зорилтын хүрээнд аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 200,000.0 мянган төгрөгийн санхүүжилтээр 7 сумын 8 багийн эмчид "Probox" маркийн автомашин олгосон байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 61 дүгээр тогтоолоор баталсан "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийн хүрээнд "Иргэдийг халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх" үзлэг хийх гэрээний дагуу 6545 өрхийн 24989 иргэний эрүүл мэндийн эрсдэлийг үнэлж, эрүүл мэндийн болон нийгмийн хэрэгцээг тодорхойлох судалгааг хийж нэгтгэсэн байна.

8225020130

Аймгийн засаг даргын Тамгын газраас байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар хөтөлбөрийн хүрээнд урьдчилан сэргийлэх үзлэг хийсэн баг, өрхийн эмч нарт болон эх баригч, сувилагчдын дунд ажил мэргэжлийн уралдааныг зохион байгуулж 246,900.0 мянган төгрөгийг олгожээ.

Тус газар нь стандартын дагуу иргэдэд ээлтэй орчин бүрдүүлж брайл үсэг, монгол бичиг, кирилл бичгээр хосолсон хаягийг 20 өрөөний үүдэнд, 5 эрүүл мэндийн байгууллагын амбулаторид дохионы хэл болон брайл үсгийн цагаан толгойг тус тус байршуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 1 хөтөлбөр, 29 зорилт, 92 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 10 зорилт 100.0 хувьтай, 16 зорилт 70.0-99.0 хувьтай, 3 зорилт эрчимжүүлэх шаардлагатай буюу 31.0-69.0 хувьтай, нийт дүнгээр 90.0 хувиар биелсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Г.ГҮНЖИДМАА



Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/

Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,362,887,295.23</u>	<u>672,741,243.12</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	1,084,887,295.23	672,741,243.12
351	Түүхий эд материал	978,229,203.48	510,723,121.83
35110	Тусгай зориулалттай материал	8,500,000.00	8,500,000.00
35130	Эм боох материал	969,729,203.48	502,223,121.83
354	Хангамжийн материал	106,658,091.75	162,018,121.29
35410	Бичиг хэргийн материал	5,955,400.00	5,114,300.00
35420	Аж ахуйн материал	87,533,711.75	136,410,161.29
35430	Сэлбэг хэрэгсэл	410,000.00	170,000.00
35440	Түлш, шатах тослох материал	10,600,500.00	19,050,160.00
35450	Барилгын засварын материал	2,158,480.00	1,273,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,389,803,632.84</u>	<u>1,319,862,104.26</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,389,803,632.84	1,319,862,104.26
392	Биет хөрөнгө	1,328,558,432.84	1,258,616,904.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,286,133,660.00	1,286,133,660.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(139,647,101.04)	(169,366,304.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	121,500,000.00	110,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(87,583,333.53)	(82,833,333.57)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	189,984,441.86	201,126,424.72
39206	Хуримтлагдсан элэгдэл	(63,140,461.05)	(104,168,798.09)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55,654,763.49	55,654,763.49
39208	Хуримтлагдсан элэгдэл	(36,621,377.29)	(40,394,584.25)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,502,111.00	2,502,111.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,563,819.60)	(1,876,583.52)
39217	Ном	1,339,549.00	1,339,549.00
393	Биет бус хөрөнгө	<u>61,245,200.00</u>	<u>61,245,200.00</u>
39301	Программ хангамж	600,000.00	600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(600,000.00)	(600,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	61,245,200.00	61,245,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,752,690,928.07</u>	<u>1,992,603,347.38</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,752,690,928.07</u>	<u>1,992,603,347.38</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,752,690,928.07	1,992,603,347.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	896,938,183.90	896,938,183.90
51101	Өмч: - төрийн	896,938,183.90	896,938,183.90
512	Хуримтлагдсан үр дүн	1,603,779,632.14	843,692,051.45
51210	Өмнөх үеийн үр дүн	1,603,779,632.14	1,603,779,632.14
51220	Тайлант үеийн үр дүн	-	(760,087,580.69)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	251,973,112.03	251,973,112.03

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,752,690,928.07</u>	<u>1,992,603,347.38</u>
---	--	-------------------------	-------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,919,108,302.83	4,533,934,473.43
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,100,616,195.83	528,506,792.43
120	Нийтлэг татварын бус орлого	1,100,616,195.83	528,506,792.43
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	125,785,940.00	31,932,382.86
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	974,830,255.83	496,574,409.57
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,818,492,107.00	4,005,427,681.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,576,191,600.00	3,626,029,881.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,576,191,600.00	3,626,029,881.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,242,300,507.00	379,397,800.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	58,682,740.00	19,108,360.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	868,801,727.00	276,178,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	314,816,040.00	84,111,240.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,594,115,897.74	5,282,772,054.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,594,115,897.74	5,282,772,054.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,222,579,570.36	2,640,226,131.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	731,984,686.53	891,706,344.43
210101	Үндсэн цалин	392,517,642.57	483,680,639.21
210102	Нэмэгдэл	235,131,637.08	274,951,899.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,786,642.00	68,230,000.00
210104	Урамшуулал	70,548,764.88	64,843,805.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,930,200.00	111,127,820.09
210201	Тэтгэврийн даатгал	63,872,600.00	75,580,873.16
210202	Тэтгэмжийн даатгал	7,514,400.00	8,926,224.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,011,500.00	4,436,712.45
210204	Ажилгүйдлийн даатгал	1,502,900.00	4,495,494.14
210205	Эрүүл мэндийн даатгал	15,028,800.00	17,688,515.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,376,485.05	76,492,868.96
210301	Гэрэл, цахилгаан	4,783,368.18	4,313,006.65
210302	Түлш, халаалт	57,911,340.87	66,039,266.31
210303	Цэвэр, бохир ус	4,681,776.00	6,140,596.00
2104	Хангамж, бараа материалын зардал	63,094,116.00	555,788,513.85
210401	Бичиг хэрэг	5,883,100.00	8,644,650.00
210402	Тээвэр, шатахуун	48,426,260.00	49,531,940.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,791,256.00	2,654,854.19
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,993,500.00	7,316,173.06
210408	Бараа материал акталсны зардал		487,400,896.60
2105	Нормативт зардал	929,440,423.26	526,255,753.56
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	922,323,877.76	526,255,753.56
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,116,545.50	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	83,599,945.01	214,597,828.46
210601	Багаж, техник, хэрэгсэл	80,251,865.01	200,413,528.46
210604	Урсгал засвар	3,348,080.00	14,184,300.00
2107	Томилолт, зочны зардал	87,916,660.00	57,943,100.00
210702	Дотоод албан томилолт	87,916,660.00	57,943,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,622,982.04	47,842,127.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,699,937.04	43,849,277.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5850	
210803	Даатгалын үйлчилгээ	294,100.00	288,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	69,620.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	32,300.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	878,100.00	2,861,800.00
210807	Газрын төлбөр	194,100.00	190,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	448,975.00	630,150.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	125,614,072.47	158,471,775.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,849,200.00	19,281,514.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,121,500.00	42,856,750.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	77,643,372.47	96,333,511.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,371,536,327.38	2,642,545,922.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,332,158,516.00	2,598,469,619.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	927,598,050.00	1,037,836,619.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	599,495,466.00	1,309,944,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	805,065,000.00	250,689,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	39,377,811.38	44,076,303.33
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,377,811.38	44,076,303.33
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	324,992,405.09	(748,837,580.69)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,537,990.00	11,250,000.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	3,537,990.00	11,250,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	321,454,415.09	(760,087,580.69)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,849,646,817.00	4,283,427,681.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,849,646,817.00	4,283,427,681.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,576,191,600.00	3,626,029,881.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,576,191,600.00	3,626,029,881.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,273,455,217.00	657,397,800.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	58,682,740.00	19,108,360.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	868,801,727.00	276,178,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	345,970,750.00	362,111,240.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,802,962,137.00	4,277,718,081.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,802,962,137.00	4,277,718,081.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,153,425,809.62	1,635,172,158.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	731,984,686.57	892,214,588.52
210101	Үндсэн цалин	392,517,642.57	492,930,077.16
210102	Нэмэгдэл	235,131,637.08	254,222,798.01
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,786,642.00	66,917,062.15
210104	Урамшуулал	70,548,764.92	78,144,651.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,930,200.00	109,238,600.00
210201	Тэтгэврийн даатгал	63,872,600.00	75,102,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,514,400.00	8,534,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,011,500.00	4,267,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,502,900.00	4,267,000.00

210205	Эрүүл мэндийн даатгал	15,028,800.00	17,067,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,376,485.05	76,552,268.96
210301	Гэрэл, цахилгаан	4,783,368.18	4,372,406.65
210302	Түлш, халаалт	57,911,340.87	66,039,266.31
210303	Цэвэр, бохир ус	4,681,776.00	6,140,596.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,581,166.00	70,061,679.31
210401	Бичиг хэрэг	7,263,600.00	6,590,300.00
210402	Тээвэр, шатахуун	28,607,960.00	57,981,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,291,706.00	2,497,179.31
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	545,600.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,872,300.00	2,752,600.00
2105	Нормативт зардал	856,000.00	57,251,630.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	656,000.00	56,880,430.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	371,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,431,080.00	244,887,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	24,999,000.00	221,400,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	460,000.00	1,139,000.00
210604	Урсгал засвар	3,972,080.00	22,348,400.00
2107	Томилолт, зочны зардал	84,536,660.00	57,943,100.00
210702	Дотоод албан томилолт	84,536,660.00	57,943,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,209,682.00	47,832,850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,699,937.00	44,384,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5850	
210803	Даатгалын үйлчилгээ	294,100.00	288,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	69,620.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	32,300.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,464,800.00	2,316,900.00
210807	Газрын төлбөр	194,100.00	190,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	448,975.00	630,150.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,519,850.00	79,190,041.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,543,850.00	36,113,641.88
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,976,000.00	43,076,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,649,536,327.38	2,642,545,922.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,332,158,516.00	2,598,469,619.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	927,598,050.00	1,037,836,619.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	599,495,466.00	1,309,944,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	805,065,000.00	250,689,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	317,377,811.38	44,076,303.33
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,507,181.38	44,076,303.33
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	278,870,630.00	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	46,684,680.00	5,709,600.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	46,684,680.00	5,709,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	46,684,680.00	5,709,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	46,684,680.00	5,709,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	46,684,680.00	5,709,600.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(46,684,680.00)	(5,709,600.00)
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0
---	---	---

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	896,938,183.90	251,973,112.03	1,603,779,632.14	2,752,690,928.07
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	896,938,183.90	251,973,112.03	1,603,779,632.14	2,752,690,928.07
3	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(760,087,580.69)	(760,087,580.69)
4	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	896,938,183.90	251,973,112.03	843,692,051.45	1,992,603,347.38

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,626,029,881.0	3,582,980,087.67	43,049,793.33	98.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,626,029,881.0	3,582,980,087.7	43,049,793.3	98.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,248,279,400.0	1,230,510,468.67	17,768,931.3	98.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	873,894,900.0	867,290,328.52	6,604,571.5	99.2
210101	Үндсэн цалин	516,379,400.0	468,005,817.16	48,373,582.8	90.6
210102	Нэмэгдэл	230,467,800.0	254,222,798.01	(23,754,998.0)	110.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	58,354,400.0	66,917,062.15	(8,562,662.2)	114.7
210104	Урамшуулал	68,693,300.0	78,144,651.20	(9,451,351.2)	113.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,238,600.0	109,238,600.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	75,102,700.0	75,102,700.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	8,534,000.0	8,534,000.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,267,000.0	4,267,000.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,267,000.0	4,267,000.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	17,067,900.0	17,067,900.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	85,903,000.0	76,552,268.96	9,350,731.0	89.1
210301	Гэрэл, цахилгаан	8,933,300.0	4,372,406.65	4,560,893.4	48.9
210302	Түлш, халаалт	68,270,200.0	66,039,266.31	2,230,933.7	96.7
210303	Цэвэр, бохир ус	8,699,500.0	6,140,596.00	2,558,904.0	70.6
2104	Хангамж, бараа материалын зардал	54,325,600.0	53,674,079.31	651,520.7	98.8
210401	Бичиг хэрэг	5,882,600.0	5,854,300.00	28,300.0	99.5
210402	Тээвэр, шатахуун	42,883,200.0	42,330,000.00	553,200.0	98.7

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,512,700.0	2,497,179.31	15,520.7	99.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	294,500.0	240,000.00	54,500.0	81.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,752,600.0	2,752,600.00	-	100.0
2105	Нормативт зардал	1,347,500.0	1,341,200.00	6,300.0	99.5
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	976,300.0	970,000.00	6,300.0	99.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	371,200.0	371,200.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,695,700.0	28,597,000.00	98,700.0	99.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,187,500.0	5,109,600.00	77,900.0	98.5
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,145,800.0	1,139,000.00	6,800.0	99.4
210604	Урсгал засвар	22,362,400.0	22,348,400.00	14,000.0	99.9
2107	Томилолт, зочны зардал	16,162,800.0	15,565,600.00	597,200.0	96.3
210702	Дотоод албан томилолт	16,162,800.0	15,565,600.00	597,200.0	96.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,192,200.0	47,832,850.00	359,350.0	99.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,384,900.0	44,384,900.00	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	83,200.0	-	83,200.0	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	288,500.0	288,500.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	84,700.0	-	84,700.0	0.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	31,700.0	22,000.00	9,700.0	69.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,316,900.0	2,316,900.00	-	100.0
210807	Газрын төлбөр	190,400.0	190,400.00	-	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	811,900.0	630,150.00	181,750.0	77.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,519,100.0	30,418,541.88	100,558.1	99.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,381,000.0	29,280,641.88	100,358.1	99.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,138,100.0	1,137,900.00	200.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,377,750,481.00	2,352,469,619.00	25,280,862.00	98.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,377,750,481.0	2,352,469,619.00	25,280,862.0	98.9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,062,903,081.0	1,037,836,619.00	25,066,462.0	97.6
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,309,944,000.0	1,309,944,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,903,400.0	4,689,000.00	214,400.0	95.6
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,626,030,028.0	3,582,980,229.67	43,049,798.3	98.8

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,626,030,028.0	3,582,980,229.67	43,049,798.3	98.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,626,029,881.0	3,582,980,087.67	43,049,793.3	98.8
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	71	71	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	39	36	3	92.3
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	27	26	1	96.3
620003	Үйлчлэх ажилтан	7	6	1	85.7
620004	Гэрээт ажилтан	4	3	1	75.0

2.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Данс	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	657,397,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	657,397,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	410,371,290.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	24,924,260.00
210101	Үндсэн цалин		24,924,260.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	16,387,600.00
210401	Бичиг хэрэг		736,000.00
210402	Тээвэр, шатахуун		15,651,600.00
2105	Нормативт зардал	-	55,910,430.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		55,910,430.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	222,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		222,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	42,377,500.00
210702	Дотоод албан томилолт		42,377,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	48,771,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		6,833,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		41,938,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	247,026,510.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	246,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		246,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,026,510.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,026,510.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	657,397,800.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	657,397,800.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	19,108,360.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		276,178,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		362,111,240.00

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар 43,811.4 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа:

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгийг 26,500.0 мянган төгрөгөөр илүү, үнэ төлбөргүй авсан орлогыг 26,500.0 мянган төгрөгөөр дутуу,
- Үр дүнгийн тайланд эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлыг 16,122.8 мянган төгрөгөөр илүү, бараа материал акталсны зардлыг 16,122.8 мянган төгрөгөөр дутуу,
- Мөнгөн гүйлгээний тайланд цалингийн зардлыг 1,188.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 37,161.8 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул "Зөрчилгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 37,161.8 мянган төгрөгийн 7 зөрчил² илэрсэнд 5 албан шаардлага, 2 зөвлөмжийг хүргүүлсэн.

3.2 Албан шаардлага

1. Цалингийн зардлаас спортын бага наадмын теннисний төрөлд амжилттай оролцож 3 дугаар байранд орсон мэргэжилтэнд 1,210.0 мянган төгрөгийн шагнал олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"; Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга өөрийн хяналт тавих чиг үүрэгт хамаарах мэргэжилтний ажлыг хавсран гүйцэтгэж 1,880.4 мянган төгрөгийн цалингийн нэмэгдэл авсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил хавсран гүйцэтгүүлэхдээ холбогдох журмыг баримтлах албан шаардлага хүргүүлсэн.

3. Байгууллагын даргын тушаал шийдвэргүй, ажлын гүйцэтгэлийг харгалзахгүйгээр хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэнд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэсгийн хорооны нарийн бичгийн даргын урамшууллыг цалингийн нэмэгдэл хэлбэрээр сар бүр

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тогтмол 20.0 хувиар тооцож, нийт 2,684.0 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/256 дугаар тушаалын гуравдугаар хавсралт "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэсгийн хорооны журам"-ын 6 дугаар зүйлийн 6.2-т "Үйл ажиллагааны зардлыг тухайн харьяалах эрүүл мэндийн байгууллагын төсөв, бусад сан, орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ. Хэсгийн хорооны жил тутмын үйл ажиллагааны зардлын төсвийг тухайн харьяалах эмнэлгийн дарга батална" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урамшууллыг олгохдоо холбогдох шийдвэрийг үндэслэн нэмэгдэл хэлбэрээр хавтгайруулан олгохгүй, тайлан баримтыг үндэслэн олгох албан шаардлага хүргүүлсэн.

4. Тээвэр шатахууны зардал 28,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй батлагдсан байхад худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах албан шаардлага хүргүүлсэн.

5. Нэмэлт санхүүжилтийн данснаас ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар зохион байгуулсан сургалтын зардал 1,100.0 мянган төгрөг, ХӨСҮТ-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн сургалтын зардал 2,287.4 мянган төгрөг, нийт 3,387.4 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн хөтлөн нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтад хяналт тавьж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын 2 автомашинд 16,580.4 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл авч засвар хийсэн боловч автомашины хувийн хэрэгт бичилт хийгээгүй, анхан шатны баримын бүрдэл хангаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"-той нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Автомашины хувийн хэрэгт сэлбэг хэрэгсэл авсан, засвар хийсэн талаарх бичилтийг тухай бүр хийж байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлж, дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:
4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулсан		Запруулаа гүй		Тоо	Дүн	Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14		
Говь-Алтай аймгийн Эрүүл мэндийн газар	Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгийг 26,500.0 мянган төгрөгөөр илүү, үнэ төлбөргүй авсан орлогыг 26,500.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	26,500.0	-	-	1	26,500.0	1	26,500.0	-	-	-	-		
	Үр дүнгийн тайланд эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлыг 16,122.8 мянган төгрөгөөр илүү, бараа материал актисны зардлыг 16,122.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	16,122.8	-	-	1	16,122.8	1	16,122.8	-	-	-	-		
	Мөнгөн гүйлгээний тайланд цалингийн зардлыг 1,188.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	1,188.6	-	-	1	1,188.6	1	1,188.6	-	-	-	-		
Дүн		3	43,811.4	-	-	3	43,811.4	3	43,811.4	-	-	-	-		



Говь-Алтай аймаг дэхь
ТОРИН АУДИТЫН
 ГАЗАР

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
	Цалингийн зардлаас шагнал олгосон.	1	1,210.00	-	-	1	1,210.00	-	-	-	-		
	Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга өөрийн хяналт тавих чиг үүрэгт хамаарах мэргэжилтний ажлыг хавсран гүйцэтгэж 1,880.4 мянган төгрөгийн цалингийн нэмэгдэл авсан.	1	1,880.40	-	-	1	1,880.40	-	-	-	-		
	Байгууллагын даргын тушаал шийдвэргүй, цалингийн нэмэгдэл авсан.	1	2,684.00	-	-	1	2,684.00	-	-	-	-		
	Тээвэр шатахууны зардал 28,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй батлагдсан байхад худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.	1	28,000.00	-	-	1	28,000.00	-	-	-	-		
	Нэмэлт санхүүжилтийн данснаас ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар зохион байгуулсан сургалтын зардал 1,100.0 мянган төгрөг, ХӨСҮТ-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн сургалтын зардал 2,287.4 мянган төгрөг, нийт 3,387.4 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу зардал гаргасан.	1	3,387.40	-	-	1	3,387.40	-	-	-	-		
	Байгууллагын 2 автомашинд 16,580.4 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл авч засвар хийсэн боловч автомашины хувийн хэрэгт бичилт хийгээгүй, анхан шатны баримын бүрдэл хангаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-		
	Дүн	6	37,161.8	-	-	5	37,161.80	1	-	-	-		

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга		Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Говь-Алтай аймгийн Эрүүл мэндийн газар		1	-	-	-	-	-	1	-	-	-	
Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 7,215,636.7 мянган төгрөгийн 277 мэдээллээс, цалингаас бусад 5 саяас дээш орлогын гүйлгээний 1,815,973.8 мянган төгрөгийн төгрөгийн 12 мэдээллийг мэдээлээгүй, 19 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.												
Нийт												
		1	-	-	-	-	-	-	-	-	-	

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Аудитад хамрагдах				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Байгууллага, нэгжийн тоо				Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			
		Санал дүгнэлт гаргасан	Түвшэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Өөрчлөлтийг Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан		
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
НИЙТ			1			1			

